

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Оршил

Ашигт малтмал, газрын тосны газрын /цаашид “агентлаг” гэх/ үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр /цаашид “хөтөлбөр” гэх/-ийн зорилго нь Засгийн газар, геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан ашигт малтмал, газрын тосны салбарын нэгдсэн бодлого, стратегийн төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны стратегийн болон зохион байгуулалтын бүтцийн загварыг тодорхойлоход оршино.

1.2. Үндэслэл

Хөтөлбөрийг боловсруулахдаа Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2016 оны 7 дугаар 27-ны өдрийн 4 дүгээр тогтоолыг тус тус үндэс болгов.

1.3. Хууль тогтоомжийн орчин:

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль
- Төсвийн тухай хууль
- Газрын тухай хууль
- Газрын хэвлийн тухай хууль
- Газрын тосны тухай хууль, түүнийг дагалдах журмууд
- Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, түүнийг дагалдах журмууд
- Ашигт малтмалын тухай хууль
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Үндэсний аюулгүй байдлын тухай хууль
- Хөрөнгө оруулалтын тухай хууль
- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль
- Цөмийн энергийн тухай хууль
- Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль
- Технологи дамжуулах тухай хууль
- Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль
- Агаарын бохирдлын тухай хууль

- Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал
- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого
- Шинэ сэргэлтийн бодлого
- Хөгжлийн зорилтот хөтөлбөр
- Төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого
- Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль
- Бусад хууль тогтоомж


1.4. Арга зүй

Энэхүү хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн ерөнхий загвар”-т нийцүүлэн боловсруулсан болно.

1.5. Ашигт малтмал, газрын тосны газрын үүрэг, хариуцлагын ерөнхий хуваарь:


Ашигт малтмал, газрын тосны газар нь геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хууль тогтоомж, бодлого, гэрээ, хэлэлцээр, стратегийн төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг, хариуцлага хүлээж, ашигт малтмал, газрын тосны асуудлаар хэрэглэгчийг мэдээллээр хангаж ажиллана.

Ашигт малтмал, газрын тосны газрын үүрэг хариуцлагын ерөнхий хуваарь



1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Ашигт малтмал, газрын тосны газрын стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг зөв тодорхойлох нь тус газрын үйл ажиллагааны стратегийг үндэслэл сайтай тогтооход чухал ач холбогдолтой юм. Энэ хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамрагдана:



Ашигт малтмал, газрын тосны газрын стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч, хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн чиг үүрэг, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

Хоёр. Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагааны стратеги

2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар:

Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Газрын тосны тухай хууль, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, Газрын тосны тухай хуулиуд, тэдгээрийн дагалдах журмууд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, салбарын бодлогын удирдамжийг хэрэгжүүлэхэд оршино.

2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

Ашигт малтмал, газрын тосны газар нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

2.2.1. Төрөөс ашигт малтмал, газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх замаар улс орны эдийн засгийн хөгжилд тус салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, ашигт малтмал, газрын тосны эрэл, хайгуулын ажлыг нэмэгдүүлж, нөөцийг өсгөх, ордыг

ашиглалтад шилжүүлэх, ашигт малтмал, газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх;

- 2.2.2. Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хангамжийн тогтвортой байдлыг хадгалах, чанар, стандартын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг хангах талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар тус салбарын улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх;
- 2.2.3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, уул уурхайн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээг судалж, хэтийн төлөвийг тодорхойлох, ашигт малтмалыг эдийн засгийн өндөр үр ашигтай, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай техник, технологи ашиглан олборлох, баяжуулах, гүн боловсруулах, борлуулахтай холбогдсон судалгаа хийж дүгнэлт гаргах, санал зөвлөмж боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, ашигт малтмал олборлох, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх;
- 2.2.4. Газрын хэвлийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор ердийн болон цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл, газрын тосны эрэл, хайгуулын болон гэрээт талбайд холбогдох үйлчилгээ үзүүлэх;

2.3. Үйл ажиллагааны эрхэм зорилго

Ашигт малтмал, газрын тосны газрын эрхэм зорилго нь төрөөс геологи, уул уурхай, газрын тосны салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулагчид, хэрэглэгчдэд хөнгөн шуурхай, шударга үйлчилгээ үзүүлэх, тус салбарт явуулж буй төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар үндэсний эдийн засгийн хөгжилд ашигт малтмал, газрын тосны салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхэд оршино.

2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт:

Ашигт малтмал, газрын тосны газар нь эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 2.4.1. Төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн удирдлагаар хангах, байгууллагын хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг оновчтой удирдах, тайлагнах, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, дүрэм, журам, стандарт боловсруулах, батлуулах, мөрдүүлэхэд эрх зүйн дэмжлэг үзүүлэх, сурталчлах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;
- 2.4.2. Ашигт малтмалын хайгуулын ажлыг эрчимжүүлэх, хайгуулын ажлын төлөвлөгөө, тайлан болон хээрийн үйлдвэрлэлийн ажилд болон хайгуулын ажлын зардлын доод хэмжээнд хяналт хийх, баталгаажуулах, хайгуулын үр дүнгээр тогтоосон нөөцийг хянах, ашигт малтмалын ордыг ашиглалтад шилжүүлэх, хаягдал, бохирдол багатай, эдийн засгийн үр ашигтай, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай техник, технологи ашиглан олборлох, боловсруулах, баяжуулах, борлуулахад чиглэсэн аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг хууль, эрх зүйн актуудын шаардлагад нийцүүлэн хянах, мэдээллийн сан үүсгэх, салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, бодлого боловсруулахад шаардлагатай суурь судалгааг хийж дүгнэлт гаргах, байгууллагын болон салбарын удирдлагыг холбогдох мэдээлэл, судалгаагаар хангах;
- 2.4.3. Газрын тосны эрэл, хайгуулын судалгааг эрчимжүүлэх, нөөцийг өсгөх, ордыг ашиглалтад шилжүүлэх, орд ашиглалтыг эрчимжүүлэн, олборлолтыг

- боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийг хангуулах, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, газрын тосны бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг тогтвортой, олон талт эх үүсвэрээс хангах, бүтээгдэхүүний чанар, стандартын шаардлагыг хангуулах, газрын тосны бүтээгдэхүүн хадгалах, түгээх байгууламжийн техник технологийн дүгнэлт гаргах, холбогдох эрх зүйн баримт, бичгийн төсөл боловсруулах, санал өгөх, мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээлэл арга зүйн зөвлөмж өгөх;
- 2.4.4. Түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуул, ашиглалтын, үүсмэл орд, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох, тэдгээрт нэгдсэн хяналт тавих, тусгай зөвшөөрөлтэй талбай болон газрын тосны эрэл, хайгуулын гэрээт талбайд холбогдох кадастрын үйлчилгээ үзүүлэх;
- 2.4.5. Агентлагийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дотоод аудит хийх, статистик мэдээллийг боловсруулах;
- 2.4.6. Газрын тосны бүтээгдэхүүн, шатах ашигт малтмал болон тэдгээрийн бүтээгдэхүүний чанарын хяналтыг хэрэгжүүлэх, төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн захиалгат шинжилгээ, туршилтыг Монгол Улсад мөрдөгдөж буй стандартын дагуу гүйцэтгэх, холбогдох зөвлөмж гаргаж, санал зөвлөмж өгөх;
- 2.4.7. Орон нутгийн хэмжээнд Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын талаарх төрийн бодлого, хөтөлбөр, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, АМГТГ-ын холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, сурталчлан таниулах;
- 2.5. Үйл ажиллагааны гол зорилт
- Ашигт малтмал, газрын тосны газрын стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны дараах гол зорилтуудыг дэвшүүлэн ажиллана:
- 2.5.1. Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:
- 2.5.1.1 Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах;
- 2.5.1.2 Агентлагийн үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах, архив, албан хэрэг хөтлөлтийг тогтмол шуурхай эрхлэн явуулах;
- 2.5.1.3 Агентлагийн эрхлэх асуудлын хүрээнд гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах;
- 2.5.1.4 Байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулах, хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах ажлыг зохион байгуулах;
- 2.5.1.5 Агентлагийн даргын шийдвэрийг хууль тогтоомжид нийцүүлэн гаргахад дэмжлэг үзүүлэх, агентлагийн эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах;
- 2.5.1.6 Түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл, бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой үйл ажиллагаанд Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль болон холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулж, биелэлтэд хяналт тавих;
- 2.5.1.7 Агентлагийн дарга /холбогдох нэгжийн удирдлага/-ын гаргасан шийдвэртэй холбоотой хэрэг, маргаанд байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалан, шүүх, хууль хяналтын бусад байгууллагад үр дүнтэйгээр төлөөлөн оролцох;
- 2.5.1.8 Агентлагийн бүтцийн нэгж, албан тушаалтнуудад ашигт малтмалын

салбарын болон төрийн албан хаагчийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх, эрх зүйн мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

2.5.2. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

- 2.5.2.1 Ашигт малтмалын чиглэлээр мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг баяжуулах;
- 2.5.2.2 Хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн хайгуулын ажлын төлөвлөгөө, тайланг хянах;
- 2.5.2.3 Хайгуулын ажлын явц, үр дүн, бодит байдалтай газар дээр нь танилцаж, шуурхай хяналт хийх;
- 2.5.2.4 Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан болон нөөцийн тооцоотой танилцаж, холбогдох эрх зүйн актуудын шаардлагад нийцүүлэн, холбогдох санал, дүгнэлт гаргаж ЭБМЗ-д хүргүүлэх;
- 2.5.2.5 Бичил уурхайн болон түгээмэл тархацтай ашигт малтмалын зориулалтаар талбай олгох дүгнэлт гаргахад дэмжлэг үзүүлэх;
- 2.5.2.6 Ашиглалтын тусгай зөвшөөрлийн нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, ТЭЗҮ, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, сарын болон долоо хоногийн мэдээгээр тогтмол баяжуулж шаардлагатай мэдээллээр холбогдох этгээдүүдэд үйлчлэх;
- 2.5.2.7 Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн олборлосон нөөцийн хөдөлгөөнийг хийх, хянах, хүлээн авах, Монгол Улсын ашигт малтмалын нөөцийн тэнцэл гаргахад шаардагдах мэдээллүүдийг боловсруулах;
- 2.5.2.8 Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч, баяжуулах, боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг холбогдох журмын дагуу хүлээн авах, мэдээллийн сан үүсгэх, судалгаа хийх, үйлдвэрлэлд ашиглаж байгаа техник, технологид үнэлэлт, дүгнэлт, санал зөвлөмж боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, олборлох, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын бодлогын бичиг баримтуудад санал бэлтгэх;
- 2.5.2.9 Шинээр хэрэгжихээр төлөвлөгдөж буй төслүүдийн ТЭЗҮ-тэй танилцаж холбогдох эрх зүйн актуудын шаардлагад нийцүүлэн, холбогдох санал, дүгнэлт гаргаж ЭМБЗ-д хүргүүлэх, төслүүдийн холбогдолтой нэгдсэн мэдээллийн сан үүсгэх;
- 2.5.2.10 Салбарын хэтийн төлөвийн тооцоо судалгааг хийж боловсруулах;
- 2.5.2.11 Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын болон татварын орчин, дотоод, гадаад зах зээлийн судалгаа, салбараас улс орны нийгэм, эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг судалж, үнэлэлт, дүгнэлт өгөх, холбогдох саналыг боловсруулах;
- 2.5.2.12 Уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл, эвдэрсэн газрыг нөхөн сэргээлтийн болон уурхайн хаалтын холбогдолтой мэдээллийг цуглуулан нэгтгэж мэдээллийн сан үүсгэх;
- 2.5.2.13 Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэр, ложистикийн сүлжээ, дэд бүтцийн болон боомтын холбоотой судалгааг хийх, холбогдох тооцоо судалгаанд тулгуурлан санал, дүгнэлт боловсруулах;
- 2.5.2.14 Салбарын мэргэжилтэй боловсон хүчний судалгааг гаргах, ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн судалгааг авч нэгтгэн мэдээллийн сан үүсгэх;
- 2.5.2.15 Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хуулиар хүлээсэн үүргийн биелэлт, тусгай зөвшөөрлийн талбайгаас олборлосон болон талбайд ногдох нөөц, улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн хайгуулын ажил, гадаадаас

- ажиллах хүч оруулж ирэх, Монгол улсын хилээр шинжилгээний дээж нэвтрүүлэх зэрэг хүсэлтүүдийг судалж үзэж тодорхойлолт гаргаж өгөх;
- 2.5.2.16 Бичил уурхайгаар ашигт малтмал олборлож буй үйл ажиллагаа болон ОУИТБС-ын холбогдолтой мэдээллийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэх;
- 2.5.2.17 Салбарын үйл ажиллагааны хууль, эрх зүйн баримт бичиг боловсруулахад мэдээллээр хангах, санал өгөх;
- 2.5.3. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:
- 2.5.3.1 Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны хууль, эрх зүйн баримт бичиг боловсруулахад мэдээллээр хангах, санал өгөх;
- 2.5.3.2 Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаарх бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах;
- 2.5.3.3 Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны өртөг нөхөгдөх зардлыг хянаж, мэргэжлийн дүгнэлт гаргах;
- 2.5.3.4 Газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих, мэдээ тайлан гаргах, салбарын үйл ажиллагааг орон нутагт сурталчлах;
- 2.5.3.5 Газрын тосны чиглэлээр эрлийн гэрээ болон бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулахад мэргэжлийн санал, дүгнэлт гаргах, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах, хэлэлцээ хийх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- 2.5.3.6 Газрын тосны хайгуулын ажлыг эрчимжүүлэх, нөөц өсгөх бодлогын хэрэгжилтийг хангах, газрын тосны эх үүсвэрийн судалгаа, хайгуулын тайлан материалыг судлах;
- 2.5.3.7 Газрын тосны төлөв байдлыг сав газар, бүс нутгаар тодорхойлох, газрын тостой холбогдсон үйл ажиллагааны мэдээллийн сан бүрдүүлэх;
- 2.5.3.8 Газрын тосны нөөцийн тооцооны тайлан болон орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд санал дүгнэлт гаргаж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд хүргүүлэх;
- 2.5.3.9 Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны орлогыг тооцох, төсөвт төвлөрүүлэх, гэрээлэгчдийн жилийн ажлын төлөвлөгөө төсвийг хянах, батлах, гэрээ хэлэлцээрт оролцох;
- 2.5.3.10 Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнээр тогтвортой хангах, хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хилийн зарим боомтоор газрын тосны бүтээгдэхүүн импортлох үйл ажиллагааг холбогдох талуудтай хамтран зохион байгуулах;
- 2.5.3.11 Улсын хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүний улсын болон компанийн нөөцийн бүрдүүлэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг зохион байгуулах;
- 2.5.3.12 Газрын тосны бүтээгдэхүүний үнийн хэлбэлзлийн талаарх судалгааг тухай бүр хийж, мэдээ, мэдээлэл гаргах;
- 2.5.3.13 Газрын тосны бүтээгдэхүүний импорт, нөөц, үлдэгдэл, жижиглэн борлуулалтын үнэ, хэрэглээ, гадаад зах зээлийн нөхцөл байдлын судалгаа хийх, холбогдох мэдээ, мэдээлэл гаргах;
- 2.5.3.14 Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах, түгээх байгууламжтай холбоотой техник технологийн дүгнэлт гаргах, холбогдох норм, дүрэм, журам, стандартын төсөлд санал өгөх, эрх зүйн баримт, бичгийн төсөл боловсруулах;

- 2.5.3.15 Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой тодорхойлолт, техник технологийн дүгнэлт гаргах, хэрэгжилтэд хяналт тавих;
 - 2.5.3.16 Газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, худалдах, тээвэрлэх, хадгалах талаар мэдээлэл арга зүйн зөвлөмж өгөх;
 - 2.5.3.17 Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станцын савыг бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх;
 - 2.5.3.18 Газрын тос боловсруулах үйлдвэр, нефть-химийн үйлдвэрийг хөгжүүлэх талаар суурь судалгаа хийх;
 - 2.5.3.19 Газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, хадгалах, худалдах үеийн чанарын хяналт хийх, холбогдох стандартын төслийг боловсруулах;
- 2.5.4. Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:
- 2.5.4.1 Ашигт малтмалын тухай хуулийн дагуу ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох;
 - 2.5.4.2 Ашигт малтмалын тухай хуулийн дагуу үүсмэл ордын тусгай зөвшөөрөл олгох;
 - 2.5.4.3 Цөмийн энергийн тухай хуулийн дагуу цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох;
 - 2.5.4.4 Тусгай зөвшөөрлийн болон зураг зүйн бүртгэлийг бүртгэж хөтлөх;
 - 2.5.4.5 Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл шинээр олгох, дахин олгох, сунгах, цуцлах, шилжүүлэх, барьцаалах, талбайг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан өгөх;
 - 2.5.4.6 Тусгай зөвшөөрлийн талаарх статистик мэдээ, мэдээлэл боловсруулж холбогдох байгууллага болон нийтэд мэдээлэх;
 - 2.5.4.7 Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн хилийн маргааныг шийдвэрлэх;
 - 2.5.4.8 Үйлчилгээний хөлс, түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг хураан авах;
 - 2.5.4.9 Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зохион явуулах, бичил уурхайн болон түгээмэл тархацтай ашигт малтмалын зориулалтаар талбай олгох дүгнэлт гаргах;
 - 2.5.4.10 Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох, ашиглах дүгнэлт гаргах;
- 2.5.5. Үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд:
- 2.5.5.1 Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дотоод аудит хийх, үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх санал боловсруулах, тайлагнах агентлагийн даргад бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;
 - 2.5.5.2 Ашигт малтмал, газрын тосны салбарын хэмжээнд статистик, тоон мэдээллийг тодорхой давтамжтайгаар боловсруулан түгээх;
- 2.5.6. Үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд:
- 2.5.6.1 Шатах ашигт малтмалын химийн найрлага, бүтэц, физик, механик шинж чанарыг тодорхойлох шинжилгээ, туршилт гүйцэтгэх;
 - 2.5.6.2 Экспортод гаргаж буй нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний чанарын төвшинг тодорхойлж, хяналт тавих, экспортын нүүрсний чанарыг дээшлүүлэх замаар үр ашгийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
 - 2.5.6.3 Шатах ашигт малтмалыг боловсруулах, баяжуулах замаар чанарын зэрэглэлийг дээшлүүлэх шинжилгээ, туршилт гүйцэтгэх;

- 2.5.6.4 Нүүрсний утаа болон механик хольцыг бууруулах, нүүрснээс нийлэг хий, хагас кокс, кокс, химийн бүтээгдэхүүн, бордоо болон бүтээгдэхүүн гаргах суурь судалгааг гүйцэтгэх, шинэ технологийн туршилтын ажлууд гүйцэтгэх;
 - 2.5.6.5 Уул уурхайн үйлдвэрүүдийн орчны хөрс, усны бохирдлын шинжилгээний үр дүнг гаргаж, төвшин тогтоох;
 - 2.5.6.6 Гадаад улсын ижил төрлийн байгууллага, олон улсын болон бусад байгууллагатай шинэ техник, технологи нэвтрүүлэх, туршлага солилцох болон бусад чиглэлээр хамтран ажиллах;
- 2.5.7. Үйл ажиллагааны стратегийн 7 дугаар зорилтын хүрээнд:
- 2.5.7.1 Ашигт малтмалын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Газрын тосны тухай хууль, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, бусад холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг тухайн бүс нутгийн хэмжээнд хангуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих, судалгаа хийх, санал боловсруулах, олон нийтэд сурталчлан танилцуулах;
- 2.6. Үйл ажиллагааны зорилт
- Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагааны гол зорилт бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилт (чиг үүрэг)-ыг ажилтан, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод тусган хэрэгжүүлнэ.
- 2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар
- Агентлагийн үйл ажиллагаа /бизнес/-ны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлсон байна.

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА(БИЗНЕС)-НЫ СТРАТЕГИ ЗАГВАР

Эрхэм зорилго

Үндсэн үйл ажиллагааны стратеги

Үйл ажиллагааны гол зорилт

Ашигт малтмал, газрын тосны газрын эрхэм зорилго нь төрөөс геологи, уул уурхай, газрын тосны салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулагчид, хэрэглэгчдэд хөнгөн шуурхай, шударга үйлчилгээ үзүүлэх, тус салбарт явуулж буй төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар үндэсний эдийн засгийн хөгжилд ашигт малтмал, газрын тосны салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхэд оршино.

Төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн удирдлагаар хангах, байгууллагын хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг оновчтой удирдах, тайлагнах, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, дүрэм, журам, стандарт боловсруулах, батлуулах, мөрдүүлэхэд эрх зүйн дэмжлэг үзүүлэх, сурталчлах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих

Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах;
Агентлагийн үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах, архив, албан хэрэг хөтлөлтийг тогтмол шуурхай эрхлэн явуулах;
Агентлагийн эрхлэх асуудлын хүрээнд гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах;
Байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулах, хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах ажлыг зохион байгуулах;
Агентлагийн даргын шийдвэрийг хууль тогтоомжид нийцүүлэн гаргахад дэмжлэг үзүүлэх, агентлагийн эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах;
Ашигт малтмал /цацраг идэвхт ашигт малтмал/, хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл, бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой үйл ажиллагаанд Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, болон холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулж, биелэлтэд хяналт тавих;
Агентлагийн дарга /холбогдох нэгжийн удирдлага/-ын гаргасан шийдвэртэй холбоотой хэрэг, маргаанд байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалан, шүүх, хууль хяналтын бусад байгууллагад үр дүнтэйгээр төлөөлөн оролцох;
Агентлагийн бүтцийн нэгж, албан тушаалтнуудад ашигт малтмалын салбарын хууль тогтоомжийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх, эрх зүйн мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах.

Түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуул, ашиглалтын, үүсмэл орд, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох, тэдгээрт нэгдсэн хяналт тавих, тусгай зөвшөөрөлтэй талбай болон газрын тосны эрэл, хайгуулын гэрээт талбайд холбогдох кадастрын үйлчилгээ үзүүлэх

Ашигт малтмалын тухай хуулийн дагуу ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох;
Ашигт малтмалын тухай хуулийн дагуу үүсмэл ордын тусгай зөвшөөрөл олгох;
Цөмийн энергийн тухай хуулийн дагуу цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох;
Тусгай зөвшөөрлийн болон зураг зүйн бүртгэлийг бүртгэж хөтлөх;
Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл шинээр олгох, дахин олгох, сунгах, цуцлах, шилжүүлэх, барьцаалах, талбайг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан өгөх;
Тусгай зөвшөөрлийн талаарх статистик мэдээ, мэдээлэл боловсруулж холбогдох байгууллага болон нийтэд мэдээлэх;
Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн хилийн маргааныг шийдвэрлэх;
Үйлчилгээний хөлс, түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг хураан авах;
Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зохион явуулах, бичил уурхайн болон түгээмэл тархацтай ашигт малтмалын зориулалтаар талбай олгох дүгнэлт гаргах;
Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох, ашиглах дүгнэлт гаргах.

Ашигт малтмалын хайгуулын ажлыг эрчимжүүлэх, хайгуулын ажлын төлөвлөгөө, тайлан болон хэргийн үйлдвэрлэлийн ажилд болон хайгуулын ажлын зардлын доод хэмжээнд хяналт хийх, баталгаажуулах, хайгуулын үр дүнгээр тогтоосон нөөцийг хянах, ашигт малтмалын ордыг ашиглалтад шилжүүлэх, хаягдал, бохирдол багатай, эдийн засгийн үр ашигтай, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай техник, технологи ашиглан олборлох, боловсруулах, баяжуулах, борлуулахад чиглэсэн аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг хууль, эрх зүйн актуудын шаардлагад нийцүүлэн хянах, мэдээллийн сан үүсгэх, салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, бодлого боловсруулахад шаардлагатай суурь судалгааг хийж дүгнэлт гаргах, байгууллагын болон салбарын удирдлагыг холбогдох мэдээлэл, судалгаагаар хангах

Ашигт малтмалын чиглэлээр мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг баяжуулах;
Хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн хайгуулын ажлын төлөвлөгөө, тайланг хянах
Хайгуулын ажлын явц, үр дүн, бодит байдалтай газар дээр нь танилцаж, шуурхай хяналт хийх
Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан болон нөөцийн тооцоотой танилцаж, холбогдох эрх зүйн актуудын шаардлагад нийцүүлэн, холбогдох санал, дүгнэлт гаргаж ЭБМЗ-д хүргүүлэх
Бичил уурхайн болон түгээмэл тархацтай ашигт малтмалын зориулалтаар талбай олгох дүгнэлт гаргахад дэмжлэг үзүүлэх;
Ашиглалтын тусгай зөвшөөрлийн нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, ТЭЗҮ, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, сарын болон долоо хоногийн мэдээгээр тогтмол баяжуулж шаардлагатай мэдээллээр холбогдох этгээдүүдэд үйлчлэх;
Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн олборлосон нөөцийн хөдөлгөөнийг хийх, хянах, хүлээн авах, Монгол Улсын ашигт малтмалын нөөцийн холбогдох журмын дагуу хүлээн авах, мэдээллийн сан үүсгэх, судалгаа хийх, үйлдвэрлэлд ашиглаж байгаа техник, технологид үнэлэлт, дүгнэлт, санал зөвлөмж боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, олборлох, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын бодлогын бичиг баримтуудад санал бэлтгэх;
Шинээр хэрэгжихээр төлөвлөгдөж буй төслүүдийн ТЭЗҮ-тэй танилцаж холбогдох эрх зүйн актуудын шаардлагад нийцүүлэн, холбогдох санал, дүгнэлт гаргаж ЭМБЗ-д хүргүүлэх, төслүүдийн холбогдолтой нэгдсэн мэдээллийн сан үүсгэх;
Салбарын хэтийн төлөвийн тооцоо судалгааг хийж боловсруулах;
Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын болон татварын орчин, дотоод, гадаад зах зээлийн судалгаа, салбараас улс орны нийгэм, эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг судалж, үнэлэлт, дүгнэлт өгөх, холбогдох саналыг боловсруулах;
Уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл, эвдэрсэн газрыг нөхөн сэргээлтийн болон уурхайн хаалтын холбогдолтой мэдээллийг цуглуулан нэгтгэж мэдээллийн сан үүсгэх;
Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэр, ложистикийн сүлжээ, дэд бүтцийн болон боомтын холбоотой судлагааг хийх, холбогдох тооцоо судалгаанд тулгуурлан санал, дүгнэлт боловсруулах;
Салбарын мэргэжилтэй боловсон хүчний судалгааг гаргах, ажиллагсадын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн судалгааг авч нэгтгэн мэдээллийн сан үүсгэх;
Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хуулиар хүлээсэн үүргийн биелэлт, тусгай зөвшөөрлийн талбайгаас олборлосон болон талбайд ногдох нөөц, улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн хайгуулын ажил, гадаадаас ажиллах хүч оруулж ирэх, Монгол улсын хилээр шинжилгээний дээж нэвтрүүлэх зэрэг хүсэлтүүдийг судалж үзэж тодорхойлолт гаргаж өгөх;
Бичил уурхайгаар ашигт малтмал олборлож буй үйл ажиллагаа болон ОУИТБС-ын холбогдолтой мэдээллийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэх;
Салбарын үйл ажиллагааны хууль, эрх зүйн баримт бичиг боловсруулахад мэдээллээр хангах, санал өгөх.

Газрын тосны эрэл, хайгуулын судалгааг эрчимжүүлэх, нөөцийг өсгөх, ордыг ашиглалтад шилжүүлэх, орд ашиглалтыг эрчимжүүлэн, олборлолтыг боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийг хангуулах, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, газрын тосны бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг тогтвортой, олон талт эх үүсвэрээс хангах, бүтээгдэхүүний чанар, стандартын шаардлагыг хангуулах, газрын тосны бүтээгдэхүүн хадгалах, түгээх байгууламжийн техник технологийн дүгнэлт гаргах, холбогдох эрх зүйн баримт, бичгийн төсөл боловсруулах, санал өгөх, мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээлэл арга зүйн зөвлөмж өгөх

Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны хууль, эрх зүйн баримт бичиг боловсруулахад мэдээллээр хангах, санал өгөх;
Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаарх бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах;
Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны өртөг нөхөгдөх зардлыг хянаж, мэргэжлийн дүгнэлт гаргах;
Газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих, мэдээ тайлан гаргах, салбарын үйл ажиллагааг орон нутагт сурталчлах;
Газрын тосны чиглэлээр эрлийн гэрээ болон бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулахад мэргэжлийн санал, дүгнэлт гаргах, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах, хэлэлцээ хийх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
Газрын тосны хайгуулын ажлыг эрчимжүүлэх, нөөц өсгөх бодлогын хэрэгжилтийг хангах, газрын тосны эх үүсвэрийн судалгаа, хайгуулын тайлан материалыг судлах;
Газрын тосны төлөв байдлыг сав газар, бүс нутгаар тодорхойлох, газрын тостой холбогдсон үйл ажиллагааны мэдээллийн сан бүрдүүлэх;
Газрын тосны нөөцийн тооцооны тайлан болон орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд санал дүгнэлт гаргаж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд хүргүүлэх;
Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны орлогыг тооцох, төсөвт төвлөрүүлэх, гэрээлэгчдийн жилийн ажлын төлөвлөгөө төсвийг хянах, батлах, гэрээ хэлэлцээрт оролцох;
Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнээр тогтвортой хангах, хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хилийн зарим боомтоор газрын тосны бүтээгдэхүүн импортлох үйл ажиллагааг холбогдох талуудтай хамтран зохион байгуулах;
Улсын хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүний улсын болон компанийн нөөцийн бүрдүүлэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг зохион байгуулах;
Газрын тосны бүтээгдэхүүний үнийн хэлбэлзлийн талаарх судалгааг тухай бүр хийж, мэдээ, мэдээлэл гаргах;
Газрын тосны бүтээгдэхүүний импорт, нөөц, үлдэгдэл, жижиглэн борлуулалтын үнэ, хэрэглээ, гадаад зах зээлийн нөхцөл байдлын судалгаа хийх, холбогдох мэдээ, мэдээлэл гаргах;
Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах, түгээх байгууламжтай холбоотой техник технологийн дүгнэлт гаргах, холбогдох норм, дүрэм, журам, стандартын төсөлд санал өгөх, эрх зүйн баримт, бичгийн төсөл боловсруулах;
Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой тодорхойлолт, техник технологийн дүгнэлт гаргах, хэрэгжилтэд хяналт тавих;
Газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, худалдах, тээвэрлэх, хадгалах талаар мэдээлэл арга зүйн зөвлөмж өгөх;
Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станцын савыг бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх;
Газрын тос боловсруулах үйлдвэр, нефть-химийн үйлдвэрийг хөгжүүлэх талаар суурь судалгаа хийх;
Газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, хадгалах, худалдах үеийн чанарын хяналт хийх, холбогдох стандартын төслийг боловсруулах.

Агентлагийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дотоод аудит хийх, статистик мэдээллийг боловсруулах

Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дотоод аудит хийх, үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх санал боловсруулах, тайлагнах агентлагийн даргад бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;
Ашигт малтмал, газрын тосны салбарын хэмжээнд статистик, тоон мэдээллийг тодорхой давтамжтайгаар боловсруулан түгээх.

Газрын тосны бүтээгдэхүүн, шатах ашигт малтмал болон тэдгээрийн бүтээгдэхүүний чанарын хяналтыг хэрэгжүүлэх, төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн захиалгат шинжилгээ, туршилтыг Монгол Улсад мөрдөгдөж буй стандартын дагуу гүйцэтгэх, холбогдох зөвлөмж гаргаж, санал зөвлөмж өгөх

Шатах ашигт малтмалын химийн найрлага, бүтэц, физик, механик шинж чанарыг тодорхойлох шинжилгээ, туршилт гүйцэтгэх;
Экспортод гаргаж буй нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний чанарын төвшинг тодорхойлж, хяналт тавих, экспортын нүүрсний чанарыг дээшлүүлэх замаар үр ашгийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
Шатах ашигт малтмалыг боловсруулах, баяжуулах замаар чанарын зэрэглэлийг дээшлүүлэх шинжилгээ, туршилт гүйцэтгэх;
Нүүрсний утаа болон механик хольцыг бууруулах, нүүрснээс нийлэг хий, хагас кокс, кокс, химийн бүтээгдэхүүн, бордоо болон бүтээгдэхүүн гаргах суурь судалгааг гүйцэтгэх, шинэ технологийн туршилтын ажлууд гүйцэтгэх;
Уул уурхайн үйлдвэрүүдийн орчны хөрс, усны бохирдлын шинжилгээний үр дүнг гаргаж, төвшин тогтоох;
Гадаад улсын ижил төрлийн байгууллага, олон улсын болон бусад байгууллагатай шинэ техник, технологи нэвтрүүлэх, туршлага солилцох болон бусад чиглэлээр хамтран ажиллах.

Орон нутгийн хэмжээнд Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын талаарх төрийн бодлого, хөтөлбөр, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, АМГТГ-ын холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, сурталчлан таниулах

Ашигт малтмалын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Газрын тосны тухай хууль, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, бусад холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг тухайн бүс нутгийн хэмжээнд хангуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих, судалгаа хийх, санал боловсруулах, олон нийтэд сурталчлан танилцуулах

Гурав. Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн чиг үүрэг

- 3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоог боловсруулахад баримтлах зарчим
Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоог боловсруулахад дор дурдсан зарчмыг баримтлав. Үүнд:
 - 3.1.1 Ашигт малтмал, газрын тосны газрын ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь тус газрын үйл ажиллагааны стратегийн зорилттой нийцсэн байх;
 - 3.1.2 Бүтцийн нэгжүүдийн нэр нь тэдгээрийн үйл ажиллагааны стратегийг тусгасан байх;
 - 3.1.3 Бүтцийн хувьд энгийн байх;
 - 3.1.4 Бүтцийн нэгжүүдийг аль болох хялбар удирдах, үйл ажиллагааг нь хянах боломжтой байх;
 - 3.1.5 Улс төржихгүй байх зарчим /тухайн агентлагийн албан хаагч нь эрхэлсэн сайд, Засгийн газар, бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчдэд төвийг сахисан өндөр мэргэшлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, улс төрийн нөлөөлөлд автахгүй байх/;
 - 3.1.6 Бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхыг бүрэн дүүрэн илрүүлэхэд чиглэсэн, хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх;
 - 3.1.7 Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх;
 - 3.1.8 Хангалттай чадавх, бодитой үйл ажиллагаа явуулах (үйл ажиллагааны ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхаа бүрэн илрүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх);
 - 3.1.9 Агентлагийн удирдлага, албан хаагчид мэргэшсэн, шуурхай бүтээлч, чирэгдэлгүй байх;
- 3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагааны стратеги болон бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримталсан зарчимд үндэслэн тус газар нь зохион байгуулалтын бүтцийн дор дурдсан нэгжүүдтэй байна. Үүнд:

1. Төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж
 - Санхүү, хөрөнгө оруулалтын нэгж;
 - Хууль, эрх зүйн нэгж;
2. Хайгуул, ашиглалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж
 - Ашигт малтмалын хайгуулын нэгж;
 - Уул уурхайн нэгж;
3. Газрын тос, бүтээгдэхүүний асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж
 - Газрын тосны хайгуулын нэгж;
 - Газрын тосны ашиглалтын нэгж (орон нутагт төлөөлөгчидтэй);
 - Газрын тосны бүтээгдэхүүний нэгж (орон нутагт төлөөлөгчидтэй);
4. Кадастрын асуудал хариуцсан нэгж;
5. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж;
6. Газрын тос, шатах ашигт малтмалын шинжилгээ, туршилтын асуудал эрхэлсэн нэгж;
7. Орон нутаг дахь төлөөлөл хариуцсан газар;
 - Баруун бүс;
 - Зүүн бүс;
 - Говийн бүс;

- Төвийн бүс;
- Хойд бүс;
- Хангайн бүс;

3.3. Зохион байгуулалтын бүтэц

Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг үндэслэн дор дурдсан зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүргийг тодорхойлж байна. Үүнд:

3.3.1. Төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, байгууллагын үйл ажиллагаанд удирдлагын тэргүүний арга барил, туршлагыг нэвтрүүлэх, хүний нөөцийн удирдлага, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, салбарын боловсон хүчнийг бэлтгэх, аж ахуй, нийтлэг үйлчилгээг хүн бүрд хүргэж үйлчлэх, байгууллагын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, нэгжүүдийн ажлын уялдаа холбоог сайжруулах, ажлаа тайлагнах, хариуцлага тооцох, үр дүнг үнэлэн дүгнэх, урамшуулах тогтолцоог боловсронгуй болгох, гадаад харилцаа, хамтын ажиллагаа, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулна.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд хуулийн нэгж, санхүүгийн нэгж ажиллана.

- Санхүү, хөрөнгө оруулалтын нэгж нь: Байгууллагын санхүү бүртгэлийн төсвийн төлөвлөлт, тайлагналын үйл ажиллагаа, газрын тос, ашигт малтмалтай холбоотой үйл ажиллагаанаас орох орлогыг тооцох, төсөвт төвлөрүүлэх.
- Хууль эрх зүйн нэгж нь: Агентлагийн даргын шийдвэрийг хууль тогтоомжид нийцүүлэн гаргахад дэмжлэг үзүүлэх, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, Ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай, Цөмийн энергийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, хяналт тавих, агентлагийн дарга /холбогдох нэгжийн удирдлага/-ын гаргасан шийдвэртэй холбоотой хэрэг, маргаанд байгууллагын эрх ашгийг шүүх, хууль хяналтын бусад байгууллагад үр дүнтэй, идэвхтэй төлөөлөн оролцох, агентлагийн бүтцийн нэгж, албан тушаалтнуудад салбарын хууль тогтоомжийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх, эрх зүйн мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний шууд хэрэглэгч нь Ашигт малтмал, газрын тосны газрын дарга, газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, тэдгээрийн ажилтнууд байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яам, Төрийн сан, Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, иргэд аж ахуйн нэгж, иргэд, шүүх, хууль хяналтын байгууллага байна.

3.3.2. Хайгуул, ашиглалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд уул уурхайн нэгж, ашигт малтмалын хайгуулын нэгж ажиллана.

- Ашигт малтмалын хайгуулын нэгж нь: Ашигт малтмалын, судалгааны бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтад ирүүлсэн баримт бичигт хавсаргасан хайгуулын ажлын төсөлд дүгнэлт гаргах, төслийн гүйцэтгэлд хяналт тавих, хайгуулын ажлын төлөвлөгөө, тайланг хянаж хүлээн авах, хайгуулын ажлын зардлын доод хэмжээг хянан баталгаажуулах, хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хүлээн авч холбогдох дүгнэлт, шийдвэрийг гаргах ажлыг зохион байгуулах, дээрх үйл ажиллагаатай холбоотой цахим мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах

материалыг судалж, санал дүгнэлт гаргах, холбогдох мэдээ мэдээллээр холбогдох төрийн захиргааны төв байгууллагыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- Уул уурхайн нэгж нь: Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч, боловсруулах, баяжуулах болон хүнд үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа эрхлэгчдэд Ашигт малтмалын тухай хууль болон салбарын бусад хууль, эрх зүйн актуудын хүрээнд үйлчилгээ үзүүлэх, салбарын аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн мэдээллүүдэд дүн шинжилгээ хийх, бүтээгдэхүүний үнэ, зах зээл, эрэлт хэрэгцээ, хөрөнгө оруулалт, татварын орчин, салбарын ойрын болон хэтийн төлөвийг тодорхойлоход шаардлагатай тооцоо, судалгаа хийх, санал боловсруулах, холбогдох төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангах ашигт малтмал олборлох, боловсруулах, хүнд үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, бодлогын удирдамжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний шууд хэрэглэгч нь агентлагийн дарга байх ба шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, ашигт малтмал хайх, олборлох, боловсруулах үйл ажиллагаа эрхэлдэг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигчид, шинжээч, судлаач, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд, гэрээлэгчид, хөрөнгө оруулагчид, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, бусад яамд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагууд, орон нутгийн өөрийн удирдах ёсны болон захиргааны байгууллагууд, олон улсын байгууллага, төрийн хяналт шалгалтын байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагууд байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Төрийн захиргааны төв байгууллага, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, агентлагийн дотоод бүтцийн нэгжүүд байна.

3.3.3. Газрын тос, бүтээгдэхүүний асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд газрын тосны хайгуул, газрын тосны ашиглалт, газрын тосны бүтээгдэхүүний нэгж тус тус ажиллана.

- Газрын тосны хайгуулын нэгж нь: Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх, нөөцийг өсгөх ажлыг зохион байгуулах, Бүтээгдэхүүн хуваах гэрээ, эрлийн гэрээний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, хайгуулын үйл ажиллагааны өртөг нөхөгдөх зардлыг хянаж, баталгаажуулахад оролцох, мэргэжлийн дүгнэлт гаргах, газрын тосны эрэл, хайгуулын үйл ажиллагаатай холбогдсон тайлан, материалыг судалж, мэдээллийн сан бий болгох, санал дүгнэлт гаргах, судалгаа хийж холбогдох мэдээ мэдээллээр төрийн захиргааны төв байгууллагыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- Газрын тосны ашиглалтын нэгж нь: Газрын тос, уламжлалт бус газрын тосны ордуудыг ашиглалтад шилжүүлэх ажлыг зохион байгуулах, дэд бүтцийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, ашиглалтыг эрчимжүүлэн олборлолтыг боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх, бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийг хангах, олборлолт, ашиглалт, хэмжилт, тээвэр, хадгалалтын үйл ажиллагаанд газар дээр нь хяналт тавих, олборлолт, ашиглалтын үйл ажиллагааны өртөг нөхөгдөх зардлыг хянаж, мэргэжлийн дүгнэлт гаргах, салбарын үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэх, холбогдох мэдээ мэдээллээр төрийн захиргааны төв байгууллагыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- Газрын тосны бүтээгдэхүүний нэгж нь: Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн талаар төрөөс баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг “Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль” болон бусад хуулийн хүрээнд зохион байгуулах, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг

хөгжүүлж, чанар, стандартын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүнээр тогтвортой хангахад дэмжлэг үзүүлэх, импортын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, улсын хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүний байнгын нөөцтэй байх зохион байгуулалтын арга хэмжээ авах, газрын тосны бүтээгдэхүүний импорт, нөөц, үлдэгдэл, жижиглэн борлуулалтын үнэ, татвар, гадаад зах зээлийн үнийн мэдээллийг тогтмол хийх, Газрын тосны бүтээгдэхүүний салбарын үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэх, Газрын тосны бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалт, түгээлтийн аюулын зэрэглэлийг бууруулсан стандартын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүний барилга байгууламж, техник технологи, тоног төхөөрөмжөөр үйл ажиллагаа явуулах санал боловсруулах, дүгнэлт гаргах, бодлогыг хэрэгжүүлэх, судалгаа хийж холбогдох мэдээ мэдээллээр төрийн захиргааны төв байгууллага болон хэрэглэгчийг мэдээллээр хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний шууд хэрэглэгч нь Ашигт малтмал, газрын тосны газрын удирдлагууд байх ба шууд бус хэрэглэгч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, холбогдох бусад яам, агентлаг, газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчид, хөрөнгө оруулагчид, орон нутгийн захиргаа, их, дээд сургуулиуд, эрдэм шинжилгээ, хил гааль, хяналт шалгалт, газрын тосны бүтээгдэхүүн, шингэрүүлсэн шатдаг хийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй импортлогч, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллагууд, мэргэжлийн холбоод, олон улсын байгууллага, хэвлэл мэдээллийн болон бусад байгууллагууд байна.

3.3.4. Кадастрын асуудал хариуцсан нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүссэн болон хөдөлгөөн хийх өргөдлийг хүлээн авах, хянан шийдвэрлэх, мэдээллийн санд бүртгэх, тусгай зөвшөөрлийг цуцлах, дуусгавар болгох, хүчингүй болгох асуудлыг хугацаанд нь шийдвэрлэх, бүртгэх, уурхайн эдэлбэрийн хил тогтоосон тухай акт хүлээн авах, баталгаажуулна. Тусгай зөвшөөрлийн төлбөр, үйлчилгээний хөлсийг бүртгэх, уул уурхайн кадастр хөтлөх, тусгай зөвшөөрөл олголт, түүний шилжилт хөдөлгөөний талаар статистик мэдээ, мэдээлэл боловсруулж гаргах, мэдээлэх, сонгон шалгаруулалтад оролцохоор хүсэлт гаргасан хуулийн этгээдийн материалыг хүлээн авах, сонирхсон этгээдэд ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн бүртгэл болон тэдгээрийн зураг зүйн бүртгэлтэй танилцах бололцоог олгох үйлчилгээ үзүүлнэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний шууд хэрэглэгч нь агентлагийн дарга байх ба шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, ашигт малтмал хайх, олборлох, боловсруулах үйл ажиллагаа эрхэлдэг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигчид, шинжээч, судлаач, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд, гэрээлэгчид, хөрөнгө оруулагчид, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, бусад яамд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагууд, орон нутгийн өөрийн удирдах ёсны болон захиргааны байгууллагууд, олон улсын байгууллага, төрийн хяналт шалгалтын байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагууд байна.

3.3.5. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дотоод аудит хийх болон статистик мэдээллийг боловсруулах үндсэн үүргийг хүлээж, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үр дүнг дүгнэх, дүгнэлт зөвлөмж гаргах, иргэд байгууллагын мэдээлэл, өргөдөл гомдлын мөрөөр дотоод аудит хийх, удирдлагын шийдвэр, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, аппаратын үйл ажиллагааны үр

нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, шаардлагатай статистик тоон мэдээллээр удирдах дээд байгууллага, иргэдийг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын үйл ажиллагаа нь удирдлагад шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, ажилтнуудын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэнэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний шууд хэрэглэгч нь газрын дарга, газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга, тэдгээрийн ажилтнууд байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, төрийн болон төрийн бус байгууллагууд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, аж ахуйн нэгж, иргэд байна.

3.3.6. Газрын тос, шатах ашигт малтмалын шинжилгээ, туршилтын асуудал эрхэлсэн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Шатах ашигт малтмалыг хаягдал, бохирдол багатай, эдийн засгийн өндөр үр ашигтай, байгаль орчинд сөрөг нөлөө багатай баяжуулах, гүн боловсруулах ажлын суурь судалгаа, уул уурхайн үйл ажиллагааны улмаас бохирдсон газрын хөрс, усны чанар, газрын тос болон газрын тосны бүтээгдэхүүний чанар, боловсруулалттай холбогдсон шинжилгээ, туршилт, судалгаа хийж дүгнэлт гаргах, санал зөвлөмж боловсруулах, ашигт малтмал боловсруулах үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Уул уурхай, газрын тосны төв лабораторийн үйл ажиллагаа нь агентлагийн дарга болон газрын аппаратад газрын тосны бүтээгдэхүүн, хатуу түлш болон тэдгээрийн бүтээгдэхүүн, уул уурхайн улмаас бохирдсон газрын хөрс, усны шинжилгээ, туршилтыг Монгол улсад болон олон улсад мөрдөгдөж буй стандарт арга аргачлалын дагуу чанарын өндөр төвшинд, хурдан шуурхай гүйцэтгэх, хэрэглэгчдэд хөнгөн шуурхай, шударга үйлчилгээ үзүүлэх, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх замаар хэрэгжинэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний шууд хэрэглэгч нь агентлагийн дарга, газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, тэдгээрийн ажилтнууд байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, төрийн болон төрийн бус байгууллагууд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, аж ахуйн нэгж, иргэд байна.

3.3.7. Орон нутаг дахь төлөөлөл хариуцсан /газар/ нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Орон нутгийн төлөөлөгчийн /газар/ нэгж нь тухайн бүс нутгийн хэмжээнд Газрын хэвлийн тухай хууль, Ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай, Цөмийн энергийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын талаарх төрийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, ажлыг зохион байгуулах, АМГТГ-ын хууль, тогтоомжоор хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, сурталчлан таниулах.

Хайгуул, ашиглалт, бүтээгдэхүүн хангамжийн үйл ажиллагааг тогтвортой, тасралтгүй явуулах арга хэмжээ авах, тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, тэдгээрийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, холбогдох мэдээлэл цуглуулах, судалгаа хийх, санал дүгнэлт боловсруулан чиг үүргийн нэгжид хүргүүлэх, тайлагнах ажлыг хэрэгжүүлнэ.

Тухайн бүс Нутгийн өөрөө удирдах байгууллага, Төрийн удирдлагын байгууллага, Төрийн захиргааны байгууллага, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж болон иргэдтэй холбогдох хууль тогтоомж, дээд удирдлага, харьяалагдах газар, хэлтсээс өгсөн чиглэлийн дагуу харилцаж, мэдээллээр хангаж, хамтран ажиллана.